ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/192/НА-СТА-ТШЗ


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

“Хаан соёмбо аудит “ХХК-ийн ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: b.dagvaa1000@gmail.com



Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга....8

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11

4. Аудитын тайлан....13

4.1 Ерөнхий зүйл ....13

4.2 Материаллаг байдал ....14

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....16

5. Аудитын илрүүлэлт ....16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.21 № 194

танай ____________-ны №____________ -т

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.БАЛЖИННЯМ-Д

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь 2024 онд газар зохион байгуулалт, геодиз, зураг зүйн газраас 11,818.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдснийг данс бүртгэлд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар барилгын захиалагчийн хяналтын зардлаас Газрын харилцаа үүсэж хөгжсөний 70 жилийн ойн арга хэмжээний хүрээнд албан хаагчдад олгосон шагналаас 460.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутган тооцоогүй, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан тэмцээн болон ойд оролцсон албан хаагчдад 18,593.0 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгосон, ойн тэмдэг, хэвлэл, подкаст хэвлэл, ном захиалах, сайн үйлсийн аянд оролцоход 8,935.0 мянган төгрөгийн зардал гаргасан, 2023 оны санхүүгийн тайлан тайлангийн аудитаар тогтоосон 4,188.6 мянган төгрөгийн төлбөрийн актыг холбогдох эздээс суутгаагүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага 1,972,572.9 мянган төгрөгийн орлоготой, 1,969,872.9 мянган


81 5 2007

төгрөгийн зардлын гүйцэтгэлтэй ажиллаж, 708,383.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь цалингийн зардлаас 62,619.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 7,764.3 мянган төгрөгийг хэмнэсэнтэй холбоотой байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| ДАНС | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 66,352,710.55 | 141,344,420.24 |
| 33 | АВЛАГА | 23,140,793.00 | 107,813,479.69 |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | - | 365,152.97 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 23,140,793.00 | 105,648,326.72 |
| 33300 | Татаас санхүүжилтийн авлага | - | 1,800,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 43,211,917.55 | 33,530,940.55 |
| 354 | Хангамжийн материал | 43,211,917.55 | 33,530,940.55 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 12,188,900.00 | 12,944,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,751,058.55 | 1,751,058.55 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 11,400,000.00 | 5,800,000.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 1,196,309.00 | 1,074,532.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 16,675,650.00 | 11,960,450.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 514,352,723.15 | 464,856,209.62 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 514,352,723.15 | 464,856,209.62 |
| 392 | Биет хөрөнгө | 504,852,723.15 | 455,356,209.62 |
| 39201 | Барилга, байгууламж | 377,273,641.66 | 377,273,641.66 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (38,885,178.86) | (46,300,052.30) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 210,191,750.00 | 210,191,750.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (155,209,805.51) | (176,493,138.83) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 414,776,861.91 | 427,495,262.03 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (333,214,771.33) | (363,818,931.94) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 80,953,007.55 | 80,953,007.55 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (51,032,782.27) | (53,945,328.55) |
| 393 | Биет бус хөрөнгө | 9,500,000.00 | 9,500,000.00 |
| 39301 | Програм хангамж | 4,464,752.02 | 4,464,752.02 |
| 39302 | Хасагдуулга | (4,464,752.02) | (4,464,752.02) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,500,000.00 | 9,500,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **580,705,433.70** | **606,200,629.86** |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 580,705,433.70 | 606,200,629.86 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 580,705,433.70 | 606,200,629.86 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 143,570,209.56 | 143,570,209.56 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 143,570,209.56 | 143,570,209.56 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 437,135,224.14 | 462,630,420.30 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 437,135,224.14 | 437,135,224.14 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 25,495,196.16 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 580,705,433.70 | 606,200,629.86 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| ДАНС | ITEM_NAME | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,342,364,240.44** | **2,068,282,298.09** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **224,505,340.44** | **275,762,880.84** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 224,505,340.44 | 275,762,880.84 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 222,422,217.44 | 263,444,480.72 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 219,858,533.00 | 263,444,480.72 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 719,440.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,844,244.44 | - |
| 120009 | Бусад орлого | 2,083,123.00 | 500,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй авсан орлого- үндсэн хөрөнгө | - | 11,818,400.12 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,117,858,900.00 | 55,281,617.25 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,111,555,900.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,111,555,900.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | 1,737,237,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 53,898,200.00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | - | 1,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | - | 800,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 52,098,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 4,900,000.00 | - |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 4,900,000.00 | - |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 1,403,000.00 | 1,383,417.25 |
| 133003 | Хөрөнгийн | 1,403,000.00 | 1,383,417.25 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **1,344,619,313.65** | **2,042,787,101.93** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,344,619,313.65** | **2,042,787,101.93** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,339,888,132.50** | **1,838,812,383.62** |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 924,565,623.00 | 1,271,054,699.60 |
| 210101 | Цалин | 492,118,285.52 | 627,726,085.32 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 318,786,679.08 | 375,338,474.69 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 49,381,890.00 | 162,187,409.54 |
| 210104 | Урамшуулал | 64,278,768.40 | 105,802,730.05 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 115,310,300.00 | 162,082,747.03 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 78,411,000.00 | 113,299,447.03 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 9,224,800.00 | 12,195,800.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 7,379,900.00 | 6,097,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,845,000.00 | 6,097,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 18,449,600.00 | 24,391,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 26,648,249.85 | 26,836,100.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 4,447,109.85 | 4,876,416.09 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 18,280,300.00 | 18,640,543.91 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 3,920,840.00 | 3,319,140.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,314,320.00 | 47,504,394.25 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 6,002,220.00 | 19,199,217.25 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 3,433,000.00 | 27,894,577.00 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 457,600.00 | 182,100.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 421,500.00 | 228,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 90,700.00 | 75,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 90,700.00 | 75,400.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 96,800.00 | 48,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 96,800.00 | 48,500,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,753,900.00 | 8,587,600.00 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 3,753,900.00 | 8,587,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 68,791,837.00 | 63,404,064.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29,432,000.00 | 7,851,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 89,600.00 | 103,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 111,800.00 | 109,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 53,000.00 | 52,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэсглийн оношилгоо | 7,900.00 | 7,700.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 39,097,537.00 | 55,280,264.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 190,316,402.65 | 210,767,378.74 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 121,052,670.00 | 148,552,465.09 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 69,263,732.65 | 62,214,913.65 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,731,181.15 | 203,974,718.31 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,468,100.00 | 133,591,100.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,468,100.00 | 3,402,200.00 |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 130,188,900.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 798,650.15 | 70,383,618.31 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 798,650.15 | 70,383,618.31 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 464,430.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 464,430.00 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт | 1.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **(2,255,073.21)** | **25,495,196.16** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)** | **(2,255,073.21)** | **25,495,196.16** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| ДАНС | ITEM_NAME | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,315,976,203.00** | **1,972,572,947.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **199,520,303.00** | **181,436,947.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 199,520,303.00 | 181,436,947.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 197,437,180.00 | 180,936,947.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 196,717,740.00 | 180,936,947.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 719,440.00 | - |
| 120009 | Бусад орлого | 2,083,123.00 | 500,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,116,455,900.00 | 1,791,136,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,111,555,900.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,111,555,900.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | 1,737,237,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 53,898,200.00 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | - | 1,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | - | 800,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 52,098,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 4,900,000.00 | - |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 4,900,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **1,292,816,603.00** | **1,969,872,947.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,292,816,603.00** | **1,969,872,947.00** |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,288,085,421.85 | 1,765,898,228.69 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 924,565,623.00 | 1,271,054,699.60 |
| 210101 | Үндсэн цалин | 492,118,285.52 | 627,726,085.32 |
| 210102 | Нэмэгдэл | 318,786,679.08 | 375,338,474.69 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 49,381,890.00 | 162,187,409.54 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 64,278,768.40 | 105,802,730.05 |
| 2102 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 115,310,300.00 | 162,447,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 78,411,000.00 | 113,664,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 9,224,800.00 | 12,195,800.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 7,379,900.00 | 6,097,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,845,000.00 | 6,097,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 18,449,600.00 | 24,391,700.00 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 26,572,649.85 | 26,836,100.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 4,447,109.85 | 4,876,416.09 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 18,204,700.00 | 18,640,543.91 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 3,920,840.00 | 3,319,140.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,151,100.00 | 14,863,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 839,000.00 | 5,967,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,433,000.00 | 8,272,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 457,600.00 | 182,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 421,500.00 | 441,100.00 |
| 2105 | Нормативт зардал | 90,700.00 | 75,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 90,700.00 | 75,400.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 96,800.00 | 48,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 96,800.00 | 48,500,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,753,900.00 | 8,587,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,753,900.00 | 8,587,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 72,861,837.00 | 63,404,064.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 33,502,000.00 | 7,851,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 89,600.00 | 103,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 111,800.00 | 109,700.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 53,000.00 | 52,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 7,900.00 | 7,700.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 39,097,537.00 | 55,280,264.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 139,682,512.00 | 170,129,165.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 139,682,512.00 | 170,129,165.09 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,731,181.15 | 203,974,718.31 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,468,100.00 | 133,591,100.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,468,100.00 | 3,402,200.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 130,188,900.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 798,650.15 | 70,383,618.31 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 798,650.15 | 70,383,618.31 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 464,430.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 464,430.00 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1.00 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 23,159,600.00 | 2,700,000.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 23,159,600.00 | 900,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 23,159,600.00 | 900,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 23,159,600.00 | 900,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 23,159,600.00 | 900,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (23,159,600.00) | (900,000.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | 1,800,000.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 143570209.6 | 0 | 439390297.4 | 582960506.9 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 143570209.6 | 0 | 439390297.4 | 582960506.9 |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0 | 0 | -2255073.21 | -2255073.21 |
| 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 143570209.6 | 0 | 437135224.1 | 580705433.7 |
| 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 143570209.6 | 0 | 437135224.1 | 580705433.7 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 143570209.6 | 0 | 437135224.1 | 580705433.7 |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0 | 0 | 25495196.16 | 25495196.16 |
| 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 143570209.6 | 0 | 462630420.3 | 606200629.9 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,625,795,400.00 | 1,561,567,499.60 | 64,227,900.40 | 96.05 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,625,795,400.00 | 1,561,567,499.60 | 64,227,900.40 | 96.05 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 1,625,795,400.00 | 1,561,567,499.60 | 64,227,900.40 | 96.05 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,333,174,000.00 | 1,270,554,699.60 | 62,619,300.40 | 95.30 |
| 210101 | Үндсэн цалин | 778,187,600.00 | 627,226,085.32 | 150,961,514.68 | 80.60 |
| 210102 | Нэмэгдэл | 487,550,500.00 | 375,338,474.69 | 112,212,025.31 | 76.98 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 22,315,800.00 | 162,187,409.54 | (139,871,609.54) | 726.78 |
| 210104 | Урамшуулал | 45,120,100.00 | 105,802,730.05 | (60,682,630.05) | 234.49 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 162,447,900.00 | 162,447,900.00 | - | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 113,664,600.00 | 113,664,600.00 | - | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,195,800.00 | 12,195,800.00 | - | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 6,097,900.00 | 6,097,900.00 | - | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,097,900.00 | 6,097,900.00 | - | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,391,700.00 | 24,391,700.00 | - | 100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 26,836,100.00 | 26,836,100.00 | - | 100.00 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 4,608,900.00 | 4,876,416.09 | (267,516.09) | 105.80 |
| 210302 | Түлш, халаалт | 18,063,300.00 | 18,640,543.91 | (577,243.91) | 103.20 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,163,900.00 | 3,319,140.00 | 844,760.00 | 79.71 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 14,863,300.00 | 14,863,300.00 | - | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,967,300.00 | 5,967,300.00 | - | 100.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 8,272,800.00 | 8,272,800.00 | - | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 182,100.00 | 182,100.00 | - | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 441,100.00 | 441,100.00 | - | 100.00 |
| 2105 | Нормативт зардал | 89,000.00 | 75,400.00 | 13,600.00 | 84.72 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 89,000.00 | 75,400.00 | 13,600.00 | 84.72 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 50,095,000.00 | 48,500,000.00 | 1,595,000.00 | 96.82 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,000,000.00 | - | 12,000,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 38,095,000.00 | 48,500,000.00 | (10,405,000.00) | 127.31 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,587,600.00 | 8,587,600.00 | - | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,587,600.00 | 8,587,600.00 | - | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 272,500.00 | 272,500.00 | - | 100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 103,100.00 | 103,100.00 | - | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 109,700.00 | 109,700.00 | - | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 52,000.00 | 52,000.00 | - | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 7,700.00 | 7,700.00 | - | 100.00 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,430,000.00 | 29,430,000.00 | - | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,430,000.00 | 29,430,000.00 | - | 100.00 |
| | ХӨТӨЛБӨР 71504 | - | - | - | - |
| | АРГА ХЭМЖЭЭ 80226 | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 7,851,300.00 | 7,851,300.00 | - | 100.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 7,851,300.00 | 7,851,300.00 | - | 100.00 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 7,851,300.00 | 7,851,300.00 | - | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 7,851,300.00 | 7,851,300.00 | - | 100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,851,300.00 | 7,851,300.00 | - | 100.00 |
| | ХӨТӨЛБӨР 71504 | - | - | - | - |
| | АРГА ХЭМЖЭЭ 80802 | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 133,591,100.00 | 133,591,100.00 | 0.00 | 100.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 133,591,100.00 | 133,591,100.00 | 0.00 | 100.00 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 133,591,100.00 | 133,591,100.00 | 0.00 | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 133,591,100.00 | 133,591,100.00 | 0.00 | 100.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,402,200.00 | 3,402,200.00 | - | 100.00 |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж | 130,188,900.00 | 130,188,900.00 | 0.00 | 100.00 |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 95,000,000.00 | 89,500,965.09 | 5,499,034.91 | 94.21 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 95,000,000.00 | 89,500,965.09 | 5,499,034.91 | 94.21 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 95,000,000.00 | 89,500,965.09 | 5,499,034.91 | 94.21 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 95,000,000.00 | 89,500,965.09 | 5,499,034.91 | 94.21 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 95,000,000.00 | 89,500,965.09 | 5,499,034.91 | 94.21 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,862,237,800.00 | 1,862,894,483.00 | (656,683.00) | 100.04 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,737,237,800.00 | 1,737,237,800.00 | - | 100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,737,237,800.00 | 1,737,237,800.00 | - | 100.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 125,000,000.00 | 125,656,683.00 | (656,683.00) | 100.53 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 125,000,000.00 | 125,656,683.00 | (656,683.00) | 100.53 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 41.00 | 41.00 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 38.00 | 38.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2.00 | 2.00 | - | 100.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *>/төгрөгөөр/*

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | ХӨТӨЛБӨР 71504 | - | - | - | - |
| | АРГА ХЭМЖЭЭ 82404 | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 52,098,200.00 | (52,098,200.00) | - |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | - | 52,098,200.00 | (52,098,200.00) | - |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | - | 52,098,200.00 | (52,098,200.00) | - |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 52,098,200.00 | (52,098,200.00) | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 52,098,200.00 | (52,098,200.00) | - |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 52,098,200.00 | (52,098,200.00) | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 52,098,200.00 | (52,098,200.00) | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 52,098,200.00 | (52,098,200.00) | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар:**

Тус байгууллага нь 46 албан хаагчидтай. Барилга хот байгуулалтын хэлтэс, Газрын удирдлагын хэлтэс, Захиргаа аж ахуйн хэлтэс гэсэн 3 хэлтэстэй. Удирдах ажилтан-1 Гүйцэтгэх ажилтан-40, үйлчилгээний ажилтан-5 байдаг

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар:** "Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын эрхэм зорилго нь аймгийн хэмжээнд геодези, зураг зүй, суурь судалгаа, газрын мониторинг, газар зохион байгуулалт, газрын кадастр, хот байгуулалт, барилгын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн амьдрах болон баялаг бүтээх эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэхэд оршино.

- **Стратеги зорилт 1:** Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баримтлан барилга байгууламж барих газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн олгож ажиллана.
- **Стратеги зорилт 2:** Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулж, ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор иргэн болгонд газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- **Стратеги зорилт 3:** Геодези, зураг зүйн орчин үеийн техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар аймгийн хэмжээнд газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч бүрийн анхан шатны бүртгэлийн хувийн хэрэг болон мэдээллийн санг бүрдүүлнэ.
- **Стратеги зорилт 4:** Газрын харилцааны талаар болон барилгын хяналтын улсын бүртгэлтэй холбогдсон төрийн үйлчилгээг нэг цэгээс, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хөнгөн шуурхай хүртээнэ.

- **Стратеги зорилт 5:** Барилга угсралтын ажлын чанар, зураг төслийн боловсруулалт, техникийн бичиг баримтын бүрдүүлэлт зэргэд барилгын норм дүрэм, стандартын шаардлагын дагуу хяналт тавьж ажиллана.

"Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх замаар бүс нутгийн болон хөдөөгийн хөгжлийг дэмжих, эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэхэд оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын *үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Төрийн албаны тухай хууль
2. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
3. Төсвийн тухай хууль
4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
5. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
7. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
8. Хөдөлмөрийн тухай хууль
9. Төрийн хэмнэлтийн тухай хууль
10. Шилэн дансны тухай хууль
11. ТБОНӨХБАҮХА тухай хууль
12. ХБТТУ-ын тухай хууль
13. Барилгын тухай хууль
14. Орон сууцны тухай хууль
15. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, геодизи зураг зүйн тухай хууль, газрын хэвлийн тухай хууль
16. Газрын төлбөрийн тухай хууль
17. хот байгуулалтын тухай хууль, хот суурин ус хангамж ариутгах татуургын тухай хууль, хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, хот байгуулалтын тухай хууль зэрэг хуулиудыг мөрдөн ажиллаж байна. Мөн холбогдох засгийн газрын тогтоолуудыг мөрдөж байна.--

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналт хэрэгжүүлэх журам, заавар боловсруулж мөрддөг байна. 3 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилогдсон болович эхний хагас жилийн байдлаар дотоод хяналт хийсэн байна. Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл болон мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын

үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 25495.2 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 23140.8 | 107813.5 | 84672.7 |
| Бараа материал | 43211.9 | 33540.9 | -9671.0 |
| Үндсэн хөрөнгө | 514352.7 | 464856.2 | 49496.5 |
| **Нийт хөрөнгө** | **580705.4** | **606200.6** | **25495.2** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 143570.2 | 143570.2 | 0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **280705.4** | **606200.6** | **25495.2** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд: Авлага:** Өмнөх оны 23140,8 мянган төгрөгийн Барилгын хяналтын орлогын авлагыг бүрэн барагдуулсан ба тайлант онд 105648.3 мянган төгрөгийн Барилгын хяналтын орлогын авлага үүсгэсэн ба 82507.5 мянган төгрөгийн зөрүүг тайлагнасан.

**Үнсэн хөрөнгө:** Өөрийн хөрөнгөөр 900.0 мянган төгрөгөөр хувилагч принтер, 11,818.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг Ерөнхий газраас шилжүүлэн авч санхүүгийн тайланд орлого авч ажилласан.

**Бараа материал:** оны эхэнд 43,211.9 мянган төгрөг байсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 30,846.1 мянган төгрөгийн бараа материал, үнэ төлбөргүйгээр 1,383.4 мянган төгрөгийн бараа шилжүүлэн авч 41,910.5 мянган төгрөгийн бараа материалыг зарлага болгон 33,530.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй үлдэж өмнөх оноос 9,671.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 143570.2 мянган төгрөг нь тайлант онд өөрчлөлт ороогүй болно.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1737237.8 мянган төгрөг, өөрийн орлогоос 125000.0 мянган төгрөг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 206,8282.3 мянган төгрөгийг улсын төсөв болон өөрийн орлогоос санхүүжсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 204,2787.1 мянган төгрөг буюу 96.05 хувьтай байна. 70,383.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь цалин 62,619.3 мянган төгрөг бараа үйлчилгээний бусад зардал 7,764.3 мянган төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Улсын төсвөөс санхүүжих** | | | | | |
| | **Ерөнхий сайд** | | | | |
| **71504** | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1862237.8 | 1862237.8 | | 100% |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 2068282.3 | 2042787.1 | 25495.2 | 96.6% |
| 82404 | Барилгын хяналтын зардал | 95000.0 | 87235.7 | 7764.3 | 91,8% |
| **НИЙТ** | | **2068282.3** | **2042787.1** | **25495.2** | **96,6%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 52,098.2 мянган төгрөг зарцуулан ажилласан.Үнээс: Барилгын хяналт хийхтэй холбоотой томилолтод 18,398.2 мянган төгрөг, шатахуунд 4,000.0 мянган төгрөг, бусад зардал 29,700.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Тайлант онд худалдан авах ажиллагаа байхгүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар

анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Хаан соёмбо аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд анхан шатны хяналт хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 53 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 1,962,633.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 39,252.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 31,402.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, санхүүгийн үр дүнгийн тайлан өөрчлөгдсөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, үр дүнгийн тайлангийн 1,962,633.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 39,252.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 31,402.1 мянган төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно..

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн бөгөөд зөвлөмж өгөөгүй, албан шаардлага аваагүй хавсарсан ажил эрхэлж байгаа 2 хүний цалин илүү тооцож олгосон 1,300.0 мянган төгрөгийн акт тавиулсныг бүрэн барагдуулсан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | **1** | **1300.0** | **1** | **1300.0** | **100%** |
| Албан шаардлага | 0 | 0 | 0 | 0 | |
| Зөвлөмж | 0 | 0 | 0 | 0 | |
| **Нийт дүн** | 1 | **1300.0** | 1 | **1300.0** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

**1.**Барилгын захиалагчийн хяналтын зардлаас бусад арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулдаг байдлыг таслан зогсоох.

2.Тус байгууллагын барилгын захиалагчийн хяналтын үүргийг гүйцэтгэж байгаа дарга, инженер болон бусад ажилтнууд томилолтоор сумдад ажиллахдаа ажил үүргийг гүйцэтгэсэн илтгэх хуудас, нотлох баримтууд шаардлагын хэмжээнд бүрдүүлэх, шатахууны зарцуулалтын замын хуудсан дээр автомашины эхний эцсийн стидомерийн заалтыг бичүүлж, тухайн ажлыг хариуцаж явсан хариуцагчийн гарын үсгээр баталгаажуулж хэвших.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23,239.6 мянган төгрөгийн алдаа илэрч 11,133.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,867.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 8,935.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

***Залруулсан алдаа: гараагүй***

Нийт илрүүлсэн илэрч 22,936.6 мянган төгрөгийн алдаа нь бидний тогтоосон материаллаг түвшингээс доогуур байгаа тул “**Өөрчлөлтгүй”** дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Байгууллагын албан хаагчдад олгосон мөнгөн шагналаас 460,000 төгрөгийн ХАОАТ суутгаагүй Газрын харилцаа үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан спортын тэмцээн болон ойн арга хэмжээнд оролцож 6,485,200 төгрөгийн томилолтын зардал барилгын захиалагчийн хяналтын зардлаас олгосон, мөн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 4,188,559 төгрөгийн төлбөрийн актыг холбогдох эздээс суутгаагүй тус зардлаас төлсөн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### 5.2 Албан шаардлага:

Газрын харилцаа үүсэж хөгжсөний 70 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 50 ширхгийн ойн тэмдгийн үнэ 867,800 төгрөг, баярын 100 ширхэг ном, товхимолын үнэ

2,000,000 төгрөгийг Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газарт шилжүүлж, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, холбогдох ном, ойн тэмдэг одоог хүртэл нийлүүлэгдээгүй зөрчил албан шаардлага өгсөн.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Зориулалт бус зарцуулалттай холбоотой асуудал***

Газрын харилцаа үүсэж хөгжсөний 70 жилийн ойн арга хэмжээний хүрээнд ойн хэвлэл захиалах, сайн үйлсийн аянд оролцох, ахмадуудыг хүлээн авахад зориулж 8,935,000 төгрөгийн зардлыг барилгын захиалагчийн хяналтын зардлаас гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" зэрэг заалтуудыг зөрчсөн байна.

***Өгсөн зөвлөмж*:** Батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган, төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгаагүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | 0 | 0 | | 0 | | 0 | | 0 | | 0 | | 0 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Байгууллагын албан хаагчдад олгосон мөнгөн шагналаас 460,000 төгрөгийн ХАОАТ суутгаагүй | 1 | 460000 | 1 | 460000 | | | | | | | | |
| Газрын харилцаа үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан спортын тэмцээн болон ойн арга хэмжээнд оролцож 6,845,200 төгрөгийн томилолтын зардал барилгын захиалагчийн хяналтын зардлаас олгосон, | 1 | 6485200 | 1 | 6485200 | | | | | | | | |
| 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 4,188,559 төгрөгийн төлбөрийн актыг холбогдох эздээс суутгаагүй тус зардлаас төлсөн | 1 | 4188559 | 1 | 4188559 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Газрын харилцаа үүсч хөгжсөний 70 жилийн ойн арга хэмжээний хүрээнд ойн тэмдэг 50ширхэгийн үнэ 867800 төгрөг, баярын ном.тохимол 100 ширхэгийн үнэ 2000,000 төгрөгийг Газар зохион байгуулалт геодиз зурагзүйн газарт шилжүүлсэн боловч хобогдох тэмдэг, ном нийлүүлэгдээгүй байна. | 1 | 2867800 | | | 1 | 2867800 | | | | | | |
| Газрын харилцаа үүсч хөгжсөний 70 жилийн ойн арга хэмжээний хүрээнд ойн хэвлэл захиалах, сайн үйлсийн аянд оролцох, ахмадуудыг хүлээн авахад зориулж 8,935,000 төгрөгийн зардлыг барилгын захиалагчийн хяналтын зардлаас гаргасан | 1 | 8935000 | | | | | 1 | 8935000 | | | | |
| **Дүн** | **5** | **22,936,559** | **3** | **11,133,759** | **1** | **2867800** | **1** | **8935000** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-20

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМО АУДИТ" ХХК

АХЛАХ АУДИТОР Б.ДАГВАСҮРЭН

Огноо: 2025-02-20